

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 03.100.01

Эрсдэлийн менежмент Удирдамж	MNS ISO 31000:2020
Risk management Guidelines	MNS ISO 31000:2017, ISO 31000:2018-ын оронд

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн С/44 дүгээр тушаалаар батлав.

Энэ стандарт нь 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ

Энэхүү стандартад байгууллагын өмнө тулгарч буй эрсдэлийг хэрхэн удирдах талаар удирдамжийг өгсөн болно. Аливаа байгууллага, түүний төлөв байдалд тохируулан эдгээр удирдамжийг хэрэглэнэ.

Энэхүү стандарт нь салбар эсвэл салбарын онцлог шинж чанараас үл хамааран бүх төрлийн эрсдэлийг удирдах нийтлэг хандлагыг бий болгоно.

Энэхүү стандартыг байгууллагын хөгжлийн бүх үед шатны шийдвэр гаргах түвшинд бүх үе шатанд бүхий л үйл ажиллагаанд ашиглах боломжтой.

2 Норматив эшлэл

Энэхүү стандартад эш татсан баримт бичиг байхгүй болно.

3 Нэр томъёо, тодорхойлолт

Энэхүү баримт бичигт дараах нэр томъёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

Стандартчиллын үйл ажиллагаанд ашиглах зорилгоор ОУСБ ба ОУЦТК нь нэр томъёоны мэдээллийн санг дараах хаягаар хадгалж, хөгжүүлж байдаг.

- ОУСБ (ISO)-ын онлайн хайлтын платформ: <http://www.iso.org/obp>
- ОУЦТК (IEC)-ийн <http://www.electropedia.org>

3.1

эрсдэл

зорилтыг тодорхой бус болгож байгаа үр нөлөө

1-р тайлбар: Хүлээгдэж буй үр дүнгээс хазайх нөхцлийг үр нөлөө гэх ба энэ нь эерэг, сөрөг эсхүл аль аль нь байж болох бөгөөд боломж эсхүл аюул заналыг бий болгож, түүнд хүргэж болно.

2-р тайлбар: Зорилт нь өөр өөр чиглэл, ангилалтай байж болох бөгөөд өөр өөр түвшинд ашиглаж болно.

3-р тайлбар: Эрсдэлийг ихэвчлэн эрсдэлийн эх үүсвэр (3.4), болзошгүй үйл явдлууд (3.5), тэдгээрийн үр дагавар (3.6), магадлал (3.7) зэргээр илэрхийлнэ.

3.2

эрсдэлийн менежмент

MNS ISO 31000:2020

байгууллагын эрсдэлийг (3.1) чиглүүлэх, хянах зохицуулалт бүхий үйл ажиллагаа

3.3

оролцогч талууд

шийдвэр эсвэл үйл ажиллагаанд нөлөөлж болох, нөлөөнд автаж болох эсвэл өөрийгөө нөлөөнд автана гэж төсөөлж буй хүн эсвэл байгууллага

1-р тайлбар: "сонирхогч тал" гэсэн нэр томъёог "оролцогч тал"-ын оронд ашиглаж болно.

3.4

эрсдэлийн эх үүсвэр

дангаараа эсвэл нийлмэл байдлаар эрсдэл(3.1)-ийг үүсгэх боломжтой элемент

3.5

тохиолдол

тодорхой нөхцөл байдал бий болох эсвэл өөрчлөгдөх

1-р тайлбар: Тохиолдол нь нэгээс олон удаа тохиолдож болох бөгөөд хэд хэдэн шалтгаан, хэд хэдэн үр дагавар (3.6)-тай байж болно.

2-р тайлбар: Тохиолдол нь хүлээлттэй байсан ч болоогүй зүйл эсвэл хүлээлтгүй байсан ч болсон зүйл байж болно.

3-р тайлбар: Тохиолдол нь эрсдэлийн эх үүсвэр байж болно.

3.6

үр дагавар

Зорилтод нөлөөлж буй тохиолдлын (3.5) үр дүн

1-р тайлбар: Үр дагавар нь тодорхой эсвэл тодорхойгүй байж болох бөгөөд зорилтод эерэг эсвэл сөрөг, шууд эсвэл шууд бус нөлөө үзүүлнэ.

2-р тайлбар: Үр дагаврыг чанараар эсхүл тоогоор илэрхийлж болно.

3-р тайлбар: Аливаа үр дагавар нь дараалсан болон хуримтлагдсан нөлөөллөөр нэмэгдэж болно.

3.7

болзошгүй тохиолдол

аливаа зүйл тохиолдох боломж

1-р тайлбар: Эрсдэлийн менежментийн (3.2) нэр томъёонд "болзошгүй тохиолдол" гэдэг үгийг объектив эсвэл субъектив байдлаар, чанарын хувьд эсвэл тоон байдлаар тодорхойлсон, ямар нэгэн зүйл тохиолдож болзошгүй байдлыг илэрхийлэхэд ашигладаг бөгөөд ерөнхий нэр томъёо эсвэл математик байдлаар үзүүлсэн байдаг (тухайн хугацаан дах магадлал эсвэл давтамж гэх мэт).

2-р тайлбар: Англи хэлний " болзошгүй тохиолдол (likelihood)" гэсэн нэр томъёо нь зарим хэл дээр шууд дүйцэх үг байдаггүй; үүний оронд "магадлал (probability)" гэсэн нэр томъёог ихэвчлэн ашиглана.

3.8

хяналт

эрсдэл (3.1)-ийг хадгалах эсхүл өөрчлөх арга хэмжээ

1-р тайлбар: Хяналт нь эрсдэлийг хадгалах эсвэл өөрчлөх зорилготой аливаа үйл явц, бодлого, тоног төхөөрөмж, дадал, эсвэл бусад нөхцөл ба/эсвэл үйлдлүүдийг агуулдаг ба эдгээрээр хязгаарлагдахгүй.

2-р тайлбар: Хяналт нь төлөвлөсөн эсвэл урьдчилан төсөөлсөн өөрчлөх үр нөлөөг үргэлж үзүүлэхгүй байж болно.

4 Зарчим

Эрсдэлийн менежментийн зорилго нь үнэ цэнийг бий болгох, хамгаалах явдал юм. Энэ нь гүйцэтгэлийг сайжруулж, инновацыг дэмжиж, зорилгодоо хүрэхэд дэмжлэг үзүүлдэг.

2-р зурагт үзүүлсэн зарчмууд нь эрсдэлийн үр дүнтэй болон үр ашигтай менежментийн шинж чанар, түүний үнэ цэний тухай ойлголт, зорилт, зорилгоо тайлбарлах зааврыг тоймлон үзүүлсэн болно.



2-р зураг - Зарчим

Үр дүнтэй эрсдэлийн менежмент нь 2-р зурагт үзүүлсэн бүрдлүүдийг шаарддаг бөгөөд үүнийг дараах байдлаар тайлбарлана.

а. Нэгдмэл байдал

Эрсдэлийн менежмент нь аливаа байгууллагын үйл ажиллагааны нэгдмэл хэсэг юм.

б. Бүтэц болон цогц байдал

Эрсдэлийн менежментэд зохион байгуулалттай, цогц байдлаар хандах нь тууштай, харьцуулж болох үр дүнд хүргэнэ.

с. Тусгайлсан байдал

Эрсдэлийн менежментийн хүрээ, үйл явц нь тухайн байгууллагын зорилго, зорилтуудтай холбоотой гадаад, дотоод нөхцөл байдалтай уялдуулан өөрчилнө.

д. Хүртээмжтэй байдал

MNS ISO 31000:2020

Оролцогч талуудыг зохих ёсоор нь цаг тухайд нь оролцуулснаар тэдний мэдлэг, үзэл бодол, ойлголтыг харгалзан үзэх боломжтой болно. Үүний үр дүнд мэдлэг, ойлголтыг сайжруулж эрсдэлийн менежментийг боловсронгуй болгоно.

е. Динамик байдал

Байгууллагын гадаад ба дотоод нөхцөл байдал өөрчлөгдөхөд эрсдэл үүсэж болзошгүй, эсхүл өөрчлөгдөж алга болно. Эрсдэлийн удирдлага нь эдгээр өөрчлөлт, тохиолдлыг цаг тухайд нь урьдчилан харж, илрүүлж, хүлээн зөвшөөрч, хариу арга хэмжээ авдаг.

f. Хамгийн сайн мэдээлэл

Эрсдэлийн менежментийн оролт нь түүхэн болон одоо байгаа мэдээлэл, цаашдын хүлээлтэд тулгуурладаг. Эрсдэлийн менежмент нь ийм мэдээлэл, хүлээлттэй холбоотой аливаа хязгаарлалт, тодорхой бус байдлыг нарийвчлан авч үздэг. Мэдээлэл нь цаг тухайдаа, тодорхой бөгөөд холбогдох оролцогч талуудад нээлттэй.

g. Хүний ба соёлын хүчин зүйл

Хүний зан төлөв, соёлын түвшин нь эрсдэлийн менежментийн үе шат бүрт бүх асуудалд ихээхэн нөлөөлдөг.

h. Байнгын сайжруулалт


Суралцах, туршлага хуримтлуулах замаар эрсдэлийн менежментийг байнга сайжруулна.

5 Цар хүрээ

5.1 Ерөнхий зүйл

Эрсдэлийн менежментийн цар хүрээний зорилго нь эрсдэлийн менежментийг байгууллагын гол үйл ажиллагаа, чиг үүрэгт нэгтгэхэд туслахад оршино. Эрсдэлийн менежментийн үр ашигтай байдал нь түүнийг байгууллагын засаглал, үүнд шийдвэр гаргах түвшинд хэрхэн нэгтгэхээс хамаарна. Энэ нь оролцогч талуудаас, ялангуяа дээд удирдлагаас дэмжлэг шаардагдана.

Цар хүрээг хөгжүүлэх нь байгууллагын хэмжээнд эрсдэлийн менежментийг нэгтгэх, төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулах ажлуудад хамаарна. 3-р зурагт цар хүрээний бүрдэл хэсгүүдийг үзүүлэв.



3-р зураг - Цар хүрээ

Байгууллага нь одоо байгаа эрсдэлийн менежментийн үйл ажиллагаа, үйл явцыг үнэлж, аливаа зөрүүг үнэлж, түүнийг цар хүрээнийхээ хүрээнд шийдвэрлэнэ. Цар хүрээний бүрдэл хэсгүүд ба тэдгээр нь хэрхэн нэгдэж ажиллах арга хэлбэрийг байгууллагын хэрэгцээнд нийцүүлэн, өөрчилбөл зохино.

5.2 Манлайлал ба үүрэг амлалт

Дээд удирдлага болон хяналтын байгууллага эрсдэлийн менежментийг байгууллагад хэрэглэх боломжтой зохион байгуулалтын бүх үйл ажиллагаанд нэгтгэж, манлайлал болон үүрэг амлалтаа дараах байдлаар илэрхийлнэ. Үүнд:

- цар хүрээний бүх бүрдлүүдийг өөрчилж, хэрэгжүүлэх;
- эрсдэлийн менежментийн хандлага, үйл ажиллагааны төлөвлөгөө, чиглэлийг тодорхойлсон мэдэгдэл, бодлого гаргах;
- эрсдэлийг удирдахад шаардлагатай нөөцөөр хангах;
- байгууллагын хэмжээнд зохих түвшинд эрх мэдэл, үүрэг ба хариуцлагыг хуваарилах.

Энэ нь байгууллагад дараах байдлаар дэмжлэг болно. Үүнд:

- эрсдэлийн менежментийг түүний зорилго, стратеги болон соёлтой уялдуулах;
- бүх үүрэг, хариуцлага түүнд сайн дурын амлалтыг хүлээн зөвшөөрч, биелүүлэх;
- эрсдэлийн шалгуур үзүүлэлтийг бий болгоход харгалзан үзэх эсхүл шаардлагагүй эрсдэлийн хэмжээ, төрлийг тогтоож, байгууллага болон түүний оролцогч талуудад мэдэгдэх боломжийг бүрдүүлэх;
- эрсдэлийн менежментийн үнэ цэнийг байгууллага болон түүний оролцогч талуудад мэдэгдэх боломжийг бүрдүүлэх;
- эрсдэлийн системтэй мониторингийг бий болгох;

MNS ISO 31000:2020

- эрсдэлийн менежментийн цар хүрээ нь байгууллагын төлөв байдалд нийцсэн хэвээр нотлох.

Дээд удирдлага нь эрсдэлийн менежментийн хэрэгжилтийг хариуцдаг бол хяналтын нэгжүүд нь эрсдэлийн менежментийн хяналтыг хариуцна. Хяналтын нэгжүүд нь ихэвчлэн дараах зүйлийг хариуцна эсвэл шаардана. Үүнд:

- байгууллагын зорилтыг тодорхойлохдоо эрсдэлийг зохих түвшинд авч үзсэн байх;
- зорилтоо хэрэгжүүлэхэд байгууллагын өмнө тулгарч буй эрсдэлийг ойлгосон байх;
- аливаа эрсдэлийг удирдах тогтолцоог хэрэгжүүлдэг, үр дүнтэй ажиллуулдаг байх;
- байгууллагын зорилгын хүрээнд эрсдэлүүд нь тохиромжтой эсэхийг нотлох
- эрсдэлийн тухай мэдээлэл, тэдгээрийн менежментийн талаар зохистой мэдээлсэн эсэх.

5.3 Нэгдмэл байдал

Эрсдэлийн менежментийг нэгтгэх нь байгууллагын бүтэц болон төлөв байдлын тухай ойлголтоос хамаарна. Байгууллагын зорилго, зорилтууд, нарийн төвөгтэй байдлаас шалтгаалан бүтэц нь ялгаатай байдаг. Байгууллагын бүтцийн бүх хэсэгт эрсдэлийг удирдана. Байгууллагын ажилтан бүр эрсдэлийг удирдах үүрэг хүлээнэ. Засаглал нь байгууллагын үйл ажиллагаа, гадаад, дотоод харилцаа, зорилгодоо хүрэхэд шаардлагатай дүрэм журам, үйл явц, дадлыг удирдан чиглүүлнэ. Удирдлагын бүтэц нь засаглалын чиглэлийг тодорхойлж, тогтвортой гүйцэтгэл, урт хугацаанд амьдрах чадавх бүхий хүссэн түвшинд хүргэхэд шаардлагатай стратеги болон зорилтыг бий болгоно. Байгууллагын дотор эрсдэлийн менежментийн хариуцлага, хяналтын үүргийг тодорхойлох нь байгууллагын засаглалын салшгүй хэсэг юм.

Эрсдэлийн менежментийг байгууллагад нэгтгэх нь динамик бөгөөд дахин давтагдах үйл явц бөгөөд байгууллагын хэрэгцээ, соёлд нийцүүлэн өөрчилнө.

Эрсдэлийн менежмент нь байгууллагын зорилго, засаглал, манлайлал, үүрэг хариуцлага, стратеги, зорилго, үйл ажиллагаанаас үл ангид буюу тэдгээрийн салшгүй хэсэг байна.

5.4 Загвар

5.4.1 Байгууллага болон түүний төлөв байдлыг ойлгох

Байгууллага эрсдэлийн менежментийн цар хүрээг боловсруулахдаа гадаад, дотоод нөхцөл байдлыг судалж, ойлгох шаардлагатай. .

Байгууллагын гадаад нөхцөл байдлыг судлахдаа дараах асуудлуудыг багтааж болох бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- олон улсын, үндэсний, бүс нутгийн эсвэл орон нутгийн нийгэм, соёл, улс төр, хууль эрх зүй, зохицуулалт, санхүү, технологи, эдийн засаг ба хүрээлэн буй орчны хүчин зүйл;
- байгууллагын зорилгод нөлөөлж буй гол хүчин зүйл болон чиг хандлага;
- гадаад оролцогч талуудын харилцаа, ойлголт, үнэ цэнэ, хэрэгцээ ба хүлээлт;
- гэрээний харилцаа ба үүрэг амлалт;

- сүлжээ ба хамаарлын нарийн төвөгтэй байдал.

Байгууллагын дотоод нөхцөл байдлыг судлахдаа дараах асуудлуудыг багтааж болох бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс;
- засаглал, байгууллагын бүтэц, үүрэг, хариуцлага;
- стратеги, зорилт, бодлого;
- байгууллагын соёл;
- байгууллагын баталсан стандарт, удирдамж, загвар;
- нөөц ба мэдлэг талаас нь ойлгох чадвар (жишээ нь: хөрөнгө, цаг хугацаа, хүмүүс, оюуны өмч, үйл явц, систем, технологи);
- өгөгдөл, мэдээллийн систем болон мэдээллийн урсгал;
- дотоод оролцогч талууд, тэдний ойлголт, үнэт зүйлийг харгалзан үзсэн харилцаа;
- гэрээний харилцаа болон үүрэг хариуцлага;
- харилцан хамаарал ба дотоод хамаарал.

5.4.2 Эрсдэлийн менежментийн талаарх үүрэг амлалт

Дээд удирдлага болон хяналтын нэгжүүд нь эрсдэлийн менежментийн талаар байгууллагын зорилго, үүрэг хариуцлагыг тодорхой илэрхийлсэн бодлого, мэдэгдэл болон бусад хэлбэрээр дамжуулан эрсдэлийн менежментийн талаар хүлээсэн үүргээ тууштай харуулж илэрхийлнэ. Үүрэг амлалтад дараах зүйлийг багтаах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй, үүнд:

- байгууллагын эрсдэлийг удирдах зорилго, түүний зорилтууд болон бусад бодлогын уялдаа;
- эрсдэлийн менежментийг байгууллагын нийт соёлд нэгтгэх хэрэгцээг дахин сайжруулах;
- эрсдэлийн менежментийг бизнесийн үндсэн үйл ажиллагаа, шийдвэр гаргах түвшинд нэгтгэхэд ажлыг удирдан чиглүүлэх;
- эрх мэдэл, үүрэг, хариуцлага;
- шаардлагатай нөөцийг бэлэн байлгах;
- зөрчилтэй зорилтуудыг шийдвэрлэх арга зам;
- байгууллагын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд хэмжих, тайлагнах;
- дүн шинжилгээ болон сайжруулах

Эрсдэлийн менежментийн талаар үүрэг амлалтыг байгууллага дотор болон холбогдох талуудад мэдээлсэн байна.

5.4.3 Байгууллагын үүрэг, эрх мэдэл, хүлээх хариуцлагыг хуваарилах

Шаардлагатай тохиолдолд дээд удирдлага болон хяналтын нэгжүүд эрсдэлийн менежменттэй холбоотой холбогдох эрх, үүрэг, хариуцлагыг байгууллагын бүх түвшинд хуваарилж, мэдээлэх бөгөөд үүнд:

- эрсдэлийн менежмент нь үндсэн үүрэг гэдгийг онцлох;
- эрсдэлийг удирдах, хариуцлага хүлээх ажилтан (эрсдэл хариуцагч)-ыг тодорхойлно.

5.4.4 Нөөцийн хуваарилалт

Шаардлагатай тохиолдолд дээд удирдлага болон хяналтын нэгжүүд эрсдэлийг удирдахад шаардлагатай дараах нөөцийг хуваарилах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй, үүнд:

- хүмүүс, ур чадвар, туршлага, чадамж;
- байгууллагын эрсдэлийг удирдахад ашиглах үйл явц, арга, хэрэгсэл;
- баримтжуулсан үйл явц болон журам;
- мэдээлэл, мэдлэгийн менежментийн тогтолцоо;
- хувийн хөгжлийн болон сургалтын хэрэгцээ

Байгууллага нь байгаа нөөцийн боломж, хязгаарлалт зэргийг харгалзан үзвэл зохино.

5.4.5 Харилцаа холбоо болон зөвлөлдөөнийг бий болгох

Байгууллага нь цар хүрээг дэмжиж, эрсдэлийн менежментийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор харилцаа холбоо, зөвлөлдөх тухай батлагдсан хандлагыг бий болгоно. Зөвлөлдөөнд зорилтот бүлгийг оролцуулж, мэдээлэл хуваалцана.

Шийдвэр гаргах эсвэл бусад үйл ажиллагаанд хувь нэмэр оруулж, сайжруулах эргэх холбоо үүсгэх хүлээлт бүхий оролцогчдыг зөвлөлдөөнд оролцуулна.

Харилцаа холбоо, зөвлөлдөх арга болон агуулга нь оролцогч талуудын хүлээлтийг шаардлагатай тохиолдолд харгалзан үзсэн байна.

Харилцаа холбоо, зөвлөлдөөн нь цаг үеэ олсон бөгөөд холбогдох мэдээллийг цуглуулах, нэгтгэх, зохих ёсоор нь бусадтай хуваалцах, эргэж холбоо тогтоож сайжруулалт хийсэн тухай эргэж мэдээлэх боломжтой байна.

5.5 Хэрэгжүүлэлт

Байгууллага нь эрсдэлийн менежментийн цар хүрээг дараах байдлаар хэрэгжүүлнэ. Үүнд:

- цаг хугацаа болон нөөц зэргийг багтаасан зохих төлөвлөгөө боловсруулах;
- байгууллагын хэмжээнд хаана, хэзээ, хэрхэн өөр өөр төрлийн шийдвэрийг, хэнээс гаргасныг тодорхойлох;
- шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах үйл явцыг өөрчлөх;
- эрсдэлийг удирдах байгууллагын зохион байгуулалтыг тодорхой ойлгож, хэрэгжүүлэлтийг хэвшүүлсэн байх.

Цар хүрээг амжилттай хэрэгжүүлэх нь оролцогч талуудын оролцоо, мэдлэг ойлголтыг шаардана. Энэ нь байгууллага шийдвэр гаргахдаа тодорхой бус байдлыг тодорхой шийдвэрлэх боломжийг олгодог бөгөөд түүнчлэн шинэ эсвэл дараагийн тодорхойгүй байдлыг харгалзан үзэх боломжийг олгоно.

Зөв боловсруулж, хэрэгжүүлсэн эрсдэлийн менежментийн цар хүрээ нь эрсдэлийн менежментийн үйл явц нь байгууллагын үйл ажиллагааны бүх хэсэг, түүний дотор шийдвэр гаргалт, гадаад, дотоод нөхцөл байдалд гарсан өөрчлөлтийг зохих ёсоор авч үзэх боломжийг олгоно.

5.6 Үнэлгээ

Эрсдэлийн менежментийн тогтолцооны үр нөлөөг үнэлэхийн тулд байгууллага нь дараах зүйлийг хийсэн байна. Үүнд:

- эрсдэлийн менежментийн цар хүрээний гүйцэтгэлийг зорилго, хэрэгжүүлэх төлөвлөгөө, шалгуур үзүүлэлт, хүлээгдэж буй төлөв байдалтай харьцуулан тогтмол хугацаанд хэмжих;
- байгууллагын зорилгод хүрэхэд дэмжлэг үзүүлэхэд тохиромжтой хэвээр байгаа эсэхийг тодорхойлох.

5.7 Сайжруулалт

5.7.1 Дасан зохицох нь

Байгууллага нь гадаад, дотоод өөрчлөлтийг шийдвэрлэхийн тулд эрсдэлийн менежментийн цар хүрээг тасралтгүй хянаж, зохицуулж байх шаардлагатай. Ингэснээр байгууллагын үнэ цэнэ нэмэгдэнэ.

5.7.2 Байнгын сайжруулалт


Байгууллага нь эрсдэлийн менежментийн цар хүрээний тохиромжтой, зорилгодоо нийцсэн, үр нөлөөтэй байдал болон эрсдэлийн менежментийн үйл явцыг нэгтгэх арга замыг байнга сайжруулж байвал зохино.

Байгууллага нь холбогдох зөрүү, сайжруулах боломжийг тодорхойлсон бол төлөвлөгөө, үүрэг даалгавар, хэрэгжүүлэх үүрэг бүхий ажилтанд хариуцуулна. Ийнхүү хэрэгжүүлэх нь эрсдэлийн менежментийг сайжруулахад хувь нэмэр оруулна.

6 Үйл явц

6.1 Ерөнхий

Эрсдэлийн менежментийн үйл явц нь харилцаа холбоо тогтоох ба зөвлөлдөх, төлөв байдлыг тогтоох, эрсдэлийг үнэлэх, бууруулах, мониторинг хийх, дүн шинжилгээ хийх, бүртгэх болон тайлагнах үйл ажиллагаанд бодлого, журам, дадлыг системтэй ашиглах байдлыг агуулна. Энэ үйл явцыг 4-р зурагт харуулав.



4-р зураг - Үйл явц

MNS ISO 31000:2020

Эрсдэлийн менежментийн үйл явц нь удирдлагын болон шийдвэр гаргалтын салшгүй хэсэг бөгөөд байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, үйл явцын нэгдмэл хэсэг байвал зохино. Үүнийг стратегийн, үйл ажиллагааны, хөтөлбөрийн эсхүл төслийн түвшинд ашиглаж болно.

Байгууллагын дотор эрсдэлийн менежментийн үйл явцын олон хэрэглээ байж болох бөгөөд зорилго болон гадаад, дотоод нөхцөл байдалд нийцүүлэн өөрчилж болно.

Хүний зан төлөв, соёлын динамик, хувьсах шинж чанарыг эрсдэлийн менежментийн үйл явцын туршид анхаарч үзвэл зохино.

Хэдийгээр эрсдэлийн менежментийн үйл явц нь дараалсан мэт боловч практик дээр энэ нь давтагдах байдалтай байдаг.

6.2 Харилцаа холбоо болон зөвлөлдөөн

Харилцаа холбоо, зөвлөлдөөний зорилго нь холбогдох оролцогч талуудад эрсдэл, шийдвэр гаргах үндэслэл, тодорхой арга хэмжээ авах болсон шалтгааныг ойлгоход туслахад оршино. Харилцаа холбоо нь эрсдэлийн талаархи ойлголт, ойлголтыг дээшлүүлэхэд чиглэгддэг бол зөвлөлдөөн нь шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх зорилгоор санал, мэдээлэл авах явдал юм. Эдгээрийн хоорондох нягт уялдаа холбоо нь мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хувь хүний нууцлалын эрхийг харгалзсан бөгөөд бодит, цаг үеэ олсон, хамааралтай, үнэн зөв, ойлгомжтой мэдээлэл солилцоход дэмжлэг үзүүлэх ёстой.

Холбогдох гадаад, дотоод оролцогч талуудтай холбоо, зөвлөлдөх уулзалт нь эрсдэлийн менежментийн үйл явцын бүх үе шатанд явагдах ёстой.

Харилцаа холбоо, зөвлөлдөөнийг дараах зорилгоор явуулна. Үүнд:

- эрсдэлийн менежментийн үйл явцын үе шат бүрд өөр өөр хүрээний туршлагыг нэгтгэх;
- эрсдэлийн шалгуурыг тодорхойлох, эрсдэлийг үнэлэхдээ өөр өөр хандлагыг зохих ёсоор авч үзэх боломжийг бүрдүүлэх;
- эрсдэлийг хянах, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх хангалттай мэдээлэл өгөх;
- эрсдэлд өртсөн хүмүүсийн дунд өөрийн оролцоо ба хамаарлын талаар мэдрэмжийг бий болгох.

6.3 Хамрах хүрээ, төлөв байдал, шалгуур

6.3.1 Ерөнхий

Хамрах хүрээ, төлөв байдал, шалгуурыг тогтоох зорилго нь эрсдэлийг үр дүнтэй үнэлж, эрсдэлийг бууруулах зохих арга хэмжээ авах боломжийг бүрдүүлэхийн тулд эрсдэлийн менежментийн үйл явцыг өөрчлөхөд оршино. Хамрах хүрээ, төлөв байдал, шалгуур зэрэгт үйл явцын хамрах хүрээг тодорхойлох, гадаад болон дотоод орчныг ойлгох зэрэг орно.

6.3.2 Хамрах хүрээг тодорхойлох нь

Байгууллага нь эрсдэлийн менежментийн үйл ажиллагааныхаа хүрээг тодорхойлно. Эрсдэлийн менежментийн үйл явцыг өөр өөр түвшинд (жишээлбэл стратегийн, үйл ажиллагааны, хөтөлбөр, төсөл эсвэл бусад үйл ажиллагаа) ашиглаж болох тул хэлэлцэж буй хамрах хүрээ, холбогдох зорилтууд болон тэдгээрийг байгууллагын зорилтуудтай уялдуулах нь чухал юм.

Хандлагыг төлөвлөхдөө дараах зүйлсийг анхаарч үзнэ, үүнд:

- хэрэгжүүлэх шаардлагатай зорилт, шийдвэр;
- үйл явцын хэрэгжүүлэх алхмуудаас хүлээгдэж буй үр дүн;
- цаг хугацаа, байршил, тусгайлсан нэмэлт, орхилт;
- эрсдэлийн үнэлгээний холбогдох арга хэрэгсэл, техник;
- шаардлагатай нөөц, хариуцлага, бүртгэл хөтөлж хадгалах;
- бусад төсөл, үйл явц, үйл ажиллагаатай хамаарал;

6.3.3 Гадаад болон дотоод төлөв байдал

Гадаад, дотоод төлөв байдал гэдэг нь байгууллага зорилгоо тодорхойлж, хүрэх орчин нь юм.

Эрсдэлийн менежментийн үйл явцын төлөв байдал нь тухайн байгууллагын үйл ажиллагаа явуулж буй гадаад, дотоод орчныг ойлгоход үндэслэх ба эрсдэлийн менежментийн үйл явцыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны тухайн орчныг тусгасан байна.

Байгууллагын төлөв байдлыг ойлгох нь чухал юм, учир нь:

- эрсдэлийн менежмент нь байгууллагын зорилго, үйл ажиллагааны хүрээнд явагддаг;
- байгууллагын хүчин зүйлс нь эрсдэлийн эх үүсвэр болж болно;
- эрсдэлийн менежментийн үйл ажиллагааны зорилго, хамрах хүрээ нь тухайн байгууллагын бүхэлдээ дэвшүүлсэн зорилттой уялдаатай байж болно.

Байгууллага 5.4.1-д дурдсан хүчин зүйлийг харгалзан эрсдэлийн менежментийн үйл явцын гадаад ба дотоод нөхцөл байдлыг тодорхойлно.

6.3.4 Эрсдэлийн шалгуурыг тодорхойлох нь

Байгууллага нь зорилтдоо холбоотойгоор авч болох эсхүл авахгүй эрсдэлийн хэмжээ, төрлийг тодорхойлно. Түүнчлэн шийдвэр гаргах үйл ажиллагааг дэмжих зорилгоор эрсдэлийн ач холбогдлыг үнэлэх шалгуурыг тогтооно. Эрсдэлийн шалгуур нь эрсдэлийн менежментийн цар хүрээтэй уялдсан, тухайн үйл ажиллагааны тодорхой зорилго, цар хүрээнд нийцүүлэн өөрчилсөн байна. Эрсдэлийн шалгуур нь байгууллагын үнэ цэнэ, зорилго, нөөцийг тусгасан байх ёстой бөгөөд эрсдэлийн менежментийн талаар баримтлах бодлого, мэдэгдэлтэй нийцэж байх ёстой. Байгууллагын үүрэг, оролцогч талуудын санал бодлыг харгалзан шалгуурыг тодорхойлно.

Эрсдэлийн шалгуурыг эрсдэлийн үнэлгээний үйл ажиллагааны эхэн үед тогтооход тэдгээр нь динамик шинжтэй бөгөөд шаардлагатай тохиолдолд тогтмол хянаж, нэмэлт, өөрчлөлт оруулж байна.

Эрсдэлийн шалгуурыг тогтоохын тулд дараах зүйлийг анхаарч үзэх хэрэгтэй, үүнд:

- үр дүн, зорилгод нөлөөлж болох тодорхойгүй байдлын шинж чанар, төрөл (биет болон биет бус);
- үр дагавар (эерэг ба сөрөг аль аль нь) болон болзошгүй тохиолдлыг хэрхэн тодорхойлох, хэмжих;
- цаг хугацааны холбоотой хүчин зүйлүүд;
- хэмжилтийг ашиглах тууштай байдал;
- эрсдэлийн түвшнийг хэрхэн тодорхойлох;
- олон эрсдэлийн хослол, дарааллыг хэрхэн авч үзэх;

MNS ISO 31000:2020

- байгууллагын чадавх.

6.4 Эрсдэлийн үнэлгээ

6.4.1 Ерөнхий

Эрсдэлийн үнэлгээ гэдэг нь эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийн дүн шинжилгээ хийх, эрсдэлийг үнэлэх үйл явц юм.

Эрсдэлийн үнэлгээг оролцогч талуудын мэдлэг, үзэл бодол дээр үндэслэн системтэй, давталттай, хамтын ажиллагааны хүрээнд хийнэ. Энэ нь боломжтой хамгийн сайн мэдээлэл, шаардлагатай бол нэмэлт лавлагааг ашиглана.

6.4.2 Эрсдэлийг тодорхойлох

Эрсдэлийг тодорхойлохын зорилго нь байгууллагын зорилгодоо хүрэхэд туслах эсвэл урьдчилан сэргийлэх боломж бүрдүүлэхийн түүнийг олох, таних, тайлбарлахад оршино. Холбогдох, тохиромжтой, хамгийн сүүлийн үеийн мэдээлэл эрсдэлийг тодорхойлоход чухал үүрэгтэй.

Байгууллага нь нэг буюу хэд хэдэн зорилгод нөлөөлж болзошгүй тодорхойгүй байдлыг тодорхойлох хэд хэдэн арга техникийг ашиглаж болно. Дараах хүчин зүйлс ба тэдгээрийн хоорондын хамаарлыг харгалзан үзвэл зохино, үүнд:

- эрсдэлийн биет ба биет бус эх үүсвэр;
- шалтгаан, тохиолдол;
- аюул занал, боломж;
- эмзэг байдал, боломж чадал;
- гадаад, дотоод нөхцөл байдлын өөрчлөлт;
- шинээр гарч ирж буй эрсдэлийн үзүүлэлтүүд;
- өмч хөрөнгө ба нөөцийн мөн чанар, үнэ цэнэ;
- үр дагавар ба түүний зорилтод үзүүлэх нөлөө;
- мэдлэгийн хязгаар болон мэдээллийн найдвартай байдал;
- цаг хугацаатай холбоотой хүчин зүйлүүд;
- оролцогчдын өрөөсгөл хандлага, төсөөлөл, итгэл үнэмшил.

Байгууллага нь түүний эх үүсвэрүүд хяналтад байгаа эсэхээс үл хамааран эрсдэлээ тодорхойлно. Төрөл бүрийн биет эсвэл биет бус үр дагаварт хүргэж болзошгүйг нэгээс илүү үр дүн байж болзошгүйг анхаарвал зохино.

6.4.3 Эрсдэлийн шинжилгээ

Эрсдэлийн шинжилгээний зорилго нь эрсдэлийн мөн чанар, түүний шинж чанарыг, шаардлагатай бол эрсдэлийн түвшнийг ойлгоход оршино. Эрсдэлийн шинжилгээнд тодорхойгүй байдал, эрсдэлийн эх үүсвэр, үр дагавар, болзошгүй тохиолдол, тохиолдол, хувилбар, хяналт болон тэдгээрийн үр нөлөөг нарийвчлан авч үзэх шаардлагатай. Тохиолдол нь олон шалтгаан, үр дагавартай байж болох бөгөөд олон зорилгод нөлөөлж болно.

Эрсдэлийн шинжилгээг зорилго, мэдээллийн хүртээмж, найдвартай байдал, байгаа нөөцөөс хамааран янз бүрийн нарийвчлал, нарийн төвөгтэй байдлаар хийж болно. Шинжилгээний арга нь нөхцөл байдал, ашиглах зориулалтаас хамааран чанарын, тоон эсвэл эдгээрийн хослол байж болно.

Эрсдэлийн шинжилгээнд дараах хүчин зүйлийг харгалзан үзнэ.

- тохиолдлын ба үр дагаврын болзошгүй тохиолдол /likelihood/;
- үр дагаврын мөн чанар, давтамж;
- нарийн төвөгтэй байдал болон хоорондын хамаарал;
- цаг хугацаатай холбоотой хүчин зүйл, хэлбэлзэл;
- одоо байгаа хяналтуудын үр нөлөө;
- мэдрэмж ба итгэлтэй байдлын түвшин.

Эрсдэлийн шинжилгээнд эрсдэлийн талаар үзэл бодлын зөрүү, нэг талыг барьсан байдал, таамаглал, шүүлт зэрэг нөлөөлж болно. Нэмэлт хүчин зүйлс нь нь ашигласан мэдээллийн чанар, хийсэн таамаглал, орхилт, аливаа техникийн хязгаарлалт, тэдгээрийг хэрхэн хэрэгжүүлэх зэрэгт нөлөөлнө. Эдгээр нөлөөллийг анхаарч, баримтжуулж, шийдвэр гаргагчдад мэдээлнэ.

Маш тодорхой бус тохиолдлыг тооцоолоход хүндрэлтэй байдаг. Асар их үр дагавартай тохиолдлыг шинжлэхэд энэ нь асуудал болж болзошгүй юм. Энэ тохиолдолд техникийн хослолыг ашиглах нь илүү ойлголтыг бий болгоно.

Эрсдэлийн шинжилгээ нь эрсдэлийг бууруулах шаардлагатай эсэх, хэрхэн бууруулах хамгийн оновчтой стратеги, аргуудыг сонгоод шийдвэр гаргахад тусална. Үр дүн нь шийдвэрүүд, хаана сонголт хийсэн талаар ойлголтыг өгч, сонголтууд нь эрсдэлийн төрөл, түвшнийг агуулсан байдаг.

6.4.4 Эрсдэлийн үнэлгээ

Эрсдэлийн үнэлгээний зорилго нь шийдвэрийг дэмжихэд оршино. Эрсдэлийн үнэлгээ нь нэмэлт арга хэмжээ шаардлагатай эсэхийг тодорхойлохын тулд эрсдэлийн дүн шинжилгээний үр дүнг тогтоосон эрсдэлийн шалгуур үзүүлэлтүүдтэй харьцуулахыг хамарна. Энэ нь дараах шийдвэрт хүргэж болно, үүнд:

Эрсдэлийн үнэлгээний зорилго нь шийдвэрийг дэмжихэд оршино. Эрсдэлийн үнэлгээ нь эрсдэлийн шинжилгээний үр дүнг тогтоосон эрсдэлийн шалгуур үзүүлэлттэй харьцуулж, нэмэлт арга хэмжээ авах шаардлагатай газрыг тодорхойлно. Энэ нь дараах шийдвэрийг гаргахад хүргэж болно.

- цаашид юуг ч хэрэгжүүлэхгүй;
- эрсдэлийг бууруулах сонголтыг авч үзэх;
- эрсдэлийг илүү сайн ойлгохын тулд нэмэлт шинжилгээ хийх;
- одоо байгаа хяналтыг хадгалах;
- зорилгоо эргэн харах.

Шийдвэр нь өргөн хүрээг хамарч, гаднын болон дотоод оролцогч талуудад учирсан бодит үр дагаврыг харгалзан үзнэ.

Эрсдэлийн үнэлгээний үр дүнг бүртгэж, мэдээлж, байгууллагын зохих түвшинд баталгаажуулна.

6.5 Эрсдэлийг бууруулах арга хэмжээ

6.5.1 Ерөнхий

Эрсдэлийг бууруулах арга хэмжээний зорилго нь эрсдэлд чиглэсэн хувилбарыг сонгох, хэрэгжүүлэхэд оршино.

Эрсдэлийг бууруулах арга хэмжээ нь давтамжтай бөгөөд дараах үйл явцыг хамарна үүнд:

- эрсдэлийг бууруулах сонголтуудыг боловсруулж, сонгох;
- эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх;

MNS ISO 31000:2020

- тухайн бууруулах арга хэмжээний үр нөлөөг үнэлэх;
- эрсдэлийг хүлээн зөвшөөрч үлдээх эсэхийг шийдэх;
- хүлээн зөвшөөрөх боломжгүй бол бууруулах арга хэмжээг үргэлжлүүлэх.

6.5.2 Эрсдэлийг бууруулах арга хэмжээний сонголт

Эрсдэлийг бууруулах хамгийн оновчтой хувилбарыг сонгох нь зорилгод хүрэхтэй холбогдон бий болох боломжит үр ашгийг хэрэгжүүлэх зардал, хүчин чармайлт, сул талуудыг тэнцвэржүүлэх явдал юм.

Эрсдэлийг бууруулах сонголтууд нь бүх тохиолдолд харилцан бие биенээ үгүйсгэх эсвэл бүгд нийцсэн байх албагүй. Эрсдэлийг бууруулах сонголтууд нь дараах зүйлсийн аль нэгийг нь агуулж болно, үүнд:

- эрсдэл үүсэх үйл ажиллагааг эхлүүлэхгүй, үргэлжлүүлэхгүй байх шийдвэр гаргах замаар эрсдэлээс зайлсхийх;
- боломжийг бий болгохын тулд эрсдэл үүрэх, нэмэгдүүлэх;
- эрсдэлийн эх үүсвэрийг арилгах;
- боломжит тохиолдлыг өөрчлөх;
- эрсдэлийг хуваалцах (жишээ нь гэрээгээр дамжуулан, даатгалд хамрагдах);
- мэдээлэлд үндэслэн шийдвэр гаргах замаар эрсдэлийг хэвээр үлдээх.

Эрсдэлийг бууруулах үндэслэл нь зөвхөн эдийн засгийн төдийгүй байгууллагын бүх үүрэг хариуцлага, сайн дурын үүрэг, оролцогч талуудын санал бодлыг харгалзан үзнэ. Эрсдэлийг бууруулах арга хэмжээний сонголтыг тухайн байгууллагын зорилго, эрсдэлийн шалгуур, боломжит нөөцийн хүрээнд хийнэ.

Эрсдэлийг бууруулах хувилбаруудыг сонгохдоо байгууллага нь оролцогч талуудын үнэ цэнэ, ойлголт, боломжит оролцоо, тэдэнтэй харилцах, зөвлөлдөх хамгийн тохиромжтой арга хэлбэрийг харгалзан үзнэ. Ижил үр дүнтэй зарим эрсдэлийг бууруулах арга хэмжээ нь бусад оролцогчдоос илүүтэйгээр зарим оролцогч талуудад илүү тохиромжтой байж болно.

Эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэдийгээр сайтар төлөвлөж, хэрэгжүүлсэн ч хүлээж байсан үр дүнд хүрэхгүй эсхүл урьдчилан хараагүй үр дагавруудыг бий болгох болзошгүй. Арга хэмжээний төрөл бүрийн хэлбэрүүд үр дүнтэй хэвээр байх баталгааг хангахын тулд мониторинг, дүн шинжилгээ нь эрсдэлийг бууруулах арга хэмжээний салшгүй хэсэг байна.

Эрсдэлийг бууруулах арга хэмжээ нь удирдах шаардлагатай шинэ эрсдэлийг илрүүлж болно.

Хэрэв бууруулах арга хэмжээний хувилбар байхгүй эсвэл хувилбар нь эрсдэлийг хангалттай хэмжээгээр өөрчилж чадахгүй тохиолдолд эрсдэлийг бүртгэж, байнгын хяналтад байлгана.

Шийдвэр гаргагч болон бусад оролцогч талууд эрсдэлийг бууруулах арга хэмжээний дараа үлдсэн эрсдэлийн мөн чанар, цар хүрээг мэдэж байвал зохино. Үлдсэн эрсдэлд мониторинг, дүн шинжилгээ хийж шаардлагатай тохиолдолд бууруулах арга хэмжээнд цаашид хамруулна.

6.5.3 Эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх

Эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зорилго нь арга хэмжээний сонгосон хувилбарыг хэрхэн хэрэгжүүлэхийг тодорхойлох бөгөөд ингэснээр арга

хэмжээг оролцогчдод ойлгуулж, төлөвлөгөөний дагуу үйл явцыг дүн шинжилгээ хийнэ. Бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд хэрэгжүүлэх дарааллыг тодорхой зааж өгнө.

Бууруулах төлөвлөгөөг зохих оролцогч талуудтай зөвлөлдсөний үндсэн дээр байгууллагын менежментийн төлөвлөгөө, үйл явцад нэгтгэсэн байна.

Арга хэмжээний төлөвлөгөөнд дараах мэдээллийг тусгана. Үүнд:

- арга хэмжээний хувилбарыг сонгох үндэслэл, түүний дотор хүлээгдэж буй үр ашиг;
- төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх үүрэгтэй, хариуцлагатай ажилтан;
- санал болгож буй арга хэмжээ;
- шаардлагатай нөөц, түүний дотор болзошгүй нөхцөл байдал;
- гүйцэтгэлийн хэмжүүрүүд;
- хязгаарлалтууд;
- шаардлагатай тайлан болон мониторинг;
- арга хэмжээг авч эхлэх ба дуусгах хугацаа.

6.6 Мониторинг ба дүн шинжилгээ

Мониторинг ба дүн шинжилгээний зорилго нь үйл явцын загвар, хэрэгжилт, үр дүнгийн чанар, үр нөлөөг баталгаажуулах, сайжруулахад оршино. Эрсдэлийн менежментийн үйл явц, үр дүнд тогтмол мониторинг хийх, үе шаттай дүн шинжилгээ хийх нь үүрэг хариуцлагыг нарийн тодорхойлсон эрсдэлийн менежментийн төлөвлөлтийн хэсэг байна.

Мониторинг ба дүн шинжилгээг үйл ажиллагааны бүх үе шатанд хийнэ. Мониторинг ба дүн шинжилгээнд төлөвлөлт, мэдээлэл цуглуулах, шинжлэх, үр дүнг бүртгэх болон эргэх холбоо үүсгэх зэрэг орно.

Мониторинг ба дүн шинжилгээний үр дүнг байгууллагын хэмжээнд гүйцэтгэлийн удирдлага, хэмжилт, тайлагнах ажиллагаанд тусгана.

6.7 Бүртгэх ба тайлагнах

Эрсдэлийн менежментийн үйл явц ба түүний үр дүнг зохих механизмын дагуу бүртгэж тайлагнана. Бүртгэх, тайлагнах зорилго нь:

- байгууллагын хэмжээнд эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа ба үр дүнг мэдээлэх;
- шийдвэр гаргалтыг мэдээллээр хангах;
- эрсдэлийн менежментийн үйл ажиллагааг сайжруулах;
- эрсдэлийн менежментийн үйл ажиллагаанд хамаарах, хариуцах, хариуцлага хүлээх оролцогч талуудтай харилцахад туслах.

Баримтжуулсан мэдээллийг бий болгох, хадгалах, ашиглахтай холбоотой шийдвэрийг гаргахдаа тэдгээрийн ашиглалт, мэдээллийн мэдрэмтгий байдал болон гадаад, дотоод төлөв байдлыг харгалзах ба эдгээрээр хязгаарлагдахгүй.

Тайлагнал нь байгууллагын засаглалын салшгүй хэсэг бөгөөд оролцогч талуудтай яриа хэлэлцээний чанарыг сайжруулж, дээд удирдлага, хяналтын байгууллагууд үүрэг хариуцлагаа биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлбэл зохино. Тайлагналд дараах анхаарах хүчин зүйлсийг анхаарах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.

- өөр өөр оролцогч талууд ба тэдгээрийн мэдээллийн хэрэгцээний онцлог, шаардлага;

MNS ISO 31000:2020

- тайлагналын зардал, давтамж, цаг үеэ олсон байдал;
- тайлагнах арга;
- мэдээлэл нь байгууллагын зорилго, шийдвэр гаргахад хамааралтай байх.

ТӨГСӨВ

Ном зүй

[1] IEC 31010, Эрсдэлийн менежмент - Эрсдэлийн үнэлгээний аргууд